



**ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар A/201

Зуунмод

┌
Мал сүргийг угаалганд
хамруулах тухай
└

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59.1, 66.1, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 6.6, 21 дүгээр зүйлийн 21.2, 21.3.1 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зуунмод сумын хэмжээнд мал, амьтны шимэгчтэх өвчний халдварлалт, тархалтыг бууруулах зорилгоор мал угаалгын ажлыг/г 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийг дуустал зохион байгуулсугай.

2. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж (Г.Цэндсүрэн)-д ДААЛГАХ нь:

2.1. Мал угаалгын ажлыг график хугацаанд стандартын шаардлага хангасан тоног хэрэгслээр хангаж, угааж шумбуулах, шүрших аргаар мал сүргийг толгой дараалан угаах ажлыг үр дүнтэй зохион байгуулах.

2.2. Малын эмийн улсын бүртгэлд бүртгэгдсэн угаалгын бодисыг зааврын дагуу тун хэмжээг тааруулан ашиглах.

2.3. Мал угаалгын ажилд оролцож байгаа малын эмч, туслах, малчин мал бүхий иргэдийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйд сайтар анхаарч мэргэжлийн заавар зөвлөмж өгч ажиллах.

3. Малчин мал бүхий иргэдэд ДААЛГАХ нь:

3.1. Паразиттах өвчнөөс урьдчилан сэргийлэх мал угаалгын ажилд мал сүргийг бүрэн хамруулж, үйлчилгээ үзүүлсэн малын эмчээр малын өрхийн эрүүл мэндийн дэвтэрт бичилт хийлгэн, угаалга хийсэн тухай баталгаажуулалт гаргаж өгөх.

3.2. Мал сүргээ угаалгах хашаа хороог засаж бэлдэх, малын эмчийн товлосон газарт бэлэн байлган, угаалга хийхэд хүн хүчээр дэмжих.

4. Графикт хугацаанд үр дүнтэй, чанартай зохион байгуулж ажиллахыг Мал эмнэлгийн тархвар зүйч (Э.Долгормаа)-д, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Н.Энхсайхан) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.САРАНГЭРЭЛ

